

I-III/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 15



Нэг ажиллагчид ногдох ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны эхний улиралд 3.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.8 (29.9%) сая төгрөгөөр өссөн байна.


Зураг 1. Нэг ажиллагчид ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, улирлаар, сая төгрөгөөр



Зураг 2. Нэг ажиллагчид ногдох ДНБ, салбараар, сая төгрөгөөр

Ерөнхий 4 салбараар авч үзвэл, нэг ажиллагчид ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж 2021 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт нэмэгдсэн байна.

Уул уурхай, олборлолтын салбарын нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг 2021 оны эхний улиралд 17.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.8 (48.7%) сая төгрөгөөр, аж үйлдвэр,



барилгынх 2.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.5 (22.4%) сая төгрөгөөр, үйлчилгээний салбарынх 2.7 сая төгрөг болж, 0.7 (32.6%) сая төгрөгөөр тус тус өсөж, хөдөө аж ахуйн салбарынх 0.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.1 (20.6%) сая төгрөгөөр буурчээ.

### Ойлголт, тодорхойлолт:

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд үйлдвэрлэл (гарц), орцын харьцаагаар тодорхойлно. Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ. Хөдөлмөрийн бүтээмжийн тооцоонд ашиглаж буй ДНБ-д өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тусгаагүй болно.

### Тооцох аргачлал:

Нэг ажиллагчид ногдох ДНБ (нэмэгдэл өртөг)-ийг ДНБ (нэмэгдэл өртөг)-ий хэмжээг ажиллагчдын тоонд хувааж тооцно.

$$P = \frac{Q}{L}$$

P – хөдөлмөрийн бүтээмж

Q – дотоодын нийт бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)

L – ажиллагчдын тоо

### Тайлбар:

Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Эх үүсвэр: ҮСХ

### Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны  
газрын дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны  
газрын Үндэсний тооцооны алба  
Утас : (976-51)-264797

